



**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ОРХОН АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2023 оны 10 сарын 20-ны өдөр

Дугаар 101

Эрдэнэт

Нэр дэвшүүлэх тухай

Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3, 65 дугаар зүйлийн 65.6 дахь хэсэг, Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын 12 дугаар зүйлийн 12.1, 12.3, 12.10 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн Орхон аймаг дахь салбар зөвлөлийн 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын Нийгмийн ажилтаны албан тушаалд төрийн албаны тусгай шалгалт өгч тэнцсэн Ганбатын Мөнхзаяаг томилуулахаар нэр дэвшүүлсүгэй.

2.Нэр дэвшигчийг томилохоос өмнө “Төрийн албаны тухай хууль”-ийн 22 дугаар зүйлийн 22.1.5-д заасны дагуу сэтгэцийн өвчин, эмгэггүй байх гэсэн шаардлагыг хангаж байгаа тухай баримтыг эрүүл мэндийн байгууллагаас авч, нэр дэвшсэн иргэнийг 2023 оны 10 дугаар сарын 25-ны дотор холбогдох албан тушаалд томилж, томилсон шийдвэрээ ирүүлэхийг Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын дарга Т.Энхжаргалд даалгасугай.

ДАРГА



Ш.ГАНБОЛД